



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 сны 07 сарын 19 өдөр

Дугаар А/239

Улаанбаатар хот

Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.12, 4.13, 4.14 дэх заалт, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын дэргэдэх дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Гишүүд:	Ц.Цэнгэл	Төрийн нарийн бичгийн дарга;
	П.Цогтсайхан	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
	Ч.Батсансар	Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга;
	В.Жавзан	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;
	Б.Батжаргал	“Астериск технологийн” ХХК-ийн санхүүгийн зөвлөх;
	Ц.Ичинхорлоо	“Хаппи бьюдинг” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч;
Нарийн бичгийн дарга:	Л.Оюунчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Төсвийн дотоод аудит хариуцсан мэргэжилтэн;

2. Дотоод аудитын хорооны хуралдааныг шаардлагатай үед шуурхай зохион байгуулж, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /В.Жавзан /-т үүрэг болгосугай.

3. Уг тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/333 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Н.ЦЭРЭНБАТ